



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 5/104

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, түр орлон
гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.3, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галшар сумын цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл нь өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс эхлэн цэцэрлэгийн эрхлэгч томилогдох хүртэл Б.Цэенхандыг цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Цэцэрлэгийн эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /Б.Энхтайван/-д даалгасугай.

3. Д.Оюунгэрэлтэй зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусган эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Б.Цэенхандын цалинг ТҮБД-н 6-ын 5 дугаар шатлал /711230/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Л.Оюунжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА